



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 17

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх,
үндсэн хөрөнгөд үнэ тогтоон дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 29,736,434 (Хорин есөн сая долоон зуун гучин зургаан мянга дөрвөн зуун гучин дөрөв) төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй 44-37 ДУА улсын дугаартай УАЗ-396295-460 фургон маркийн автомашиныг нэгдүгээр хавсралтын дагуу Засаг даргын Тамгын газарт шилжүүлэх, 13,000,000 (Арван гурван сая) төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй 92-38 ДУА улсын дугаартай TOYOTO ALPHARD HYBRID маркийн автомашиныг хоёрдугаар хавсралтаар нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг тус тус зөвшөөрсүгэй.

2. Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн дарга (Ц.Ариунтуяа), Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Отгонбаатар) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Шилжүүлэх хөрөнгийг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх

2.2. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д үүрэг болгосугай.

ДАРГА




Ж.МӨНХЧУЛУУН

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн
17 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон он	Санхүүгийн тайланд тусгагдсан дүн	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Сери	Дугаар						
1	Эрүүл мэндийн төв	Alphard	ДУА	9238	2003	2017	13,000,000	13,000,000	-	5,000,000
Нийт дүн							13,000,000 (арван гурван сая) төгрөг	13,000,000 (арван гурван сая) төгрөг		5,000,000 (таван сая)

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн
17 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашигдалтад орсон он	Санхүүгийн тайланд тусгагдсан дүн	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Сери	Дугаар						
1	Эрүүл мэндийн төв	Alphard	ДУА	9238	2003	2017	13,000,000	13,000,000	-	5,000,000
Нийт дүн							13,000,000 (арван гурван сая) төгрөг	13,000,000 (арван гурван сая) төгрөг		5,000,000 (таван сая)